



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

«Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн»
Мөрөөр авах арга хэмжээний тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4.3, 5.1.3, 11.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн үр дүнгээс цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг нийт албан хаагчдад танилцуулах, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболдод даалгасугай.

2. Дараах арга хэмжээ авч ажиллахыг хэлтэс, албадын дарга нарт үүрэг болгосугай:

2.1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зөвлөмжид дурдсан агуулгын хүрээнд хэрэгжүүлж ажиллах;

2.2. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн тайлангийн хүрээнд төлөвлөсөн зорилт, арга хэмжээнд хүрээгүй, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журмыг хууль эрх зүйн үндэслэлд нийцүүлэн шинэчлэн боловсруулах.

3.Байгууллагын цахим ил тод байдлыг нэмэгдүүлэх, сайжруулах чиглэлээр цахим хуудаст тавигдах шаардлагын дагуу мэдээллүүдийг тухай бүр оруулж, шинэчлэл хийж, 2022 онд цахим ил тод байдлын индексийг хангалттай түвшинд хүргэж ажиллахыг Мэдээлэл, технологийн албаны дарга Д.Будхүүд үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболдод даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132005060

ТӨБЗГ тушаал-2022